БАТЛАВ: БАРУУНБҮРЭН СУМЫН ЗАСАГ ДАРГА Б.ОТГОНБААСАН

СЭЛЭНГЭ АЙМАГ БАРУУНБҮРЭН СУМЫН ДЭД БҮТЭЦИЙН БАРИЛГА БАЙГУУЛАМЖ, ИНЖЕНЕРИЙН ШУГАМ СҮЛЖЭЭНИЙ ЗУРАГ ТӨСВИЙН АЖЛЫН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ДААЛГАВАР

2025 – 05 - 01 № 01 Сэлэнгэ аймаг

1	Зураг төсөл боловсруулах үндэслэл	- Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр - Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2025 -2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр - Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумын Засаг даргын 2025 -2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр
2	Байршил, инженерийн шугам сүлжээний одоогийн байдал	Байршил: Сэлэнгэ аймгийн баруун урд хэсэгт Улаанбаатар хотоос 320 км, аймгийн төвөөс 210 км зайд байрладаг. Сумын төвд 1450 хүн амьдардаг **Инженерийн шугам сүлжээ түүнийг хангах эх үүсвэр:** - Одоо байгаа төвлөрсөн дулаан хангамжийн эх үүсвэр, дулааны 3 хос шугамыг өргөтгөх , цэвэр усны эх үүсвэр, төв шугамыг бүрэн шинэчлэх - Айл өрхүүдийг цэвэр, дулаан, бохир усаар шинээр хангах - Нэгдсэн дулааны эх үүсвэрийг сумын төвөөс гаргаж шинээр төлөвлөх - Сумын төвийн уст цэгийн судалгаа хийж цэвэр усны эх үүсвэрийн худгууд гаргах. Хамгаалалтын бүс тогтоож орчноос тусгаарлах хашаа барих - Цэвэр усны эх үүсвэрийн худгийн барилга, нөөцийн усан сангийн барилга төлөвлөх - Нэгдсэн бохир усны шугамыг төлөвлөх ба хэрэглэгчийн хүчин чадал болон хүн өсөн нэмэгдэх - хэрэглээг тооцож цэвэрлэх байгууламж төлөвлөх - Дулааны эх үүсвэр, цэвэрлэх байгууламж, цэвэр усны эх үүсвэрийн барилгуудын гадна цахилгаан хангамжийн ажил
М 3	Хамрах хүрээ, газар нутгийн хэмжээ	- Сумын төвийн одоогийн сууршлын бүсийг хамруулан цаашид өсөн нэмэгдэх боломжтойгоор тооцон төлөвлөнө. - Захиалагч байгууллагатай зөвшилцөнө
4	Зураг төсөл боловсруулах ажлын үе шат	- <u>Нэгдүгээр үе шат:</u> Байр зүйн болон дэвсгэр зураг; • Инженер геологийн судалгаа хийж, дүгнэлт гаргах • Сумын төвийн одоогийн шугам сүлжээний эх үүсвэр, шугам сүлжээний судалгаа хийж, төлөвлөлтөөр дулаан хангамж, хэрэглээний халуун ус, цэвэр усан хангамжийн үүсвэр, ариутгах татуурга, холбоожуулалт, цахилгаан хангамжийн шугам сүлжээний эх үүсвэр, шугам сүлжээг судлах • Баруунбүрэн сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө. • Сумын төвийн одоогийн зам талбай, ногоон байгууламжийн судалгаа хийж төлөвлөж болох орон зайг судлах • Инженерийн шугам сүлжээг батлагдсан ерөнхий төлөвлөгөө, сумаас гарсан саналтай уялдуулж төлөвлөх. • Барилга хот байгуулалтын яамнаас боловсруулсан нэг маягийн зурагт холболт хийж, ашиглаж болно. - Хоёрдугаар үе шат: Ажлын зураг төсөл боловсруулах • Эскиз /батлагдсан/ • Ажлын зураг /батлагдсан/ • Төсөв /батлагдсан/ • Зураг төсөлд иж бүрэн магадлал хийлгэх
5	Зураг төсөл боловсруулахад ашиглах материал	<u>Монгол Улсын хуулиуд:</u> - Хот байгуулалтын тухай хууль;/ - Барилгын тухай хууль; - Газрын тухай хууль;

		- Хот суурин газрын ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль; - Эрчим хүчний тухай хууль; - Бусад хууль тогтоомж; <u>Бодлогын баримт бичиг, төсөл, хөтөлбөрүүд:</u> - Монгол Улсын урт хугацааны хөгжлийн баримт бичиг "Алсын хараа 2050"; - Ногоон хөгжлийн бодлого; - Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр; - Баруунбүрэн сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө - Бусад. <u>Норм норматив, стандарт:</u> - Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм (БНбД 30-01-04); - 1:500, 1:1000, 1:2000, 1:5000-ны масштабтай байр зүйн дэвсгэр зураглалын ажил БД 11-106-08; - Барилга байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгүйн норм ба дүрэм /БНбД 21.02.02/ - "Инженерийн шугам сүлжээний зураглалын ажил" БД11-105- 06 (БХБ-ын Сайдын 2006 оны 116 дугаар тушаал); - "Ус, дулаан хангамж, ариутгах татуургын сүлжээ, үерийн усны байгууламжийн геодезийн ажил" БД-11-115-16 (БХБ-ын Сайдын 2016 оны 25 дугаар тушаал); - "Усны барилга байгууламжийн зураг төсөл зохиох үндсэн журам" БНбД 33-01-03 (ДБС-ын 2003 оны 134 дүгээр тушаал); - "Ариутгах татуурга.Гадна сүлжээ ба байгууламж" БНбД 40-01- 14 (БХБ-ын сайдын 2014 оны 90 дүгээр тушаал); - "Ус хангамж. Гадна сүлжээ ба байгууламж" БНбД 40-02-16 (БХБ-ын сайдын 2016 оны 116 дугаар тушаал); - "Дулааны сүлжээ" БНбД 41-02-13 (БХБ-ын сайдын 2014 оны 136 дугаар тушаал); - "Бие даасан дулааны эх үүсвэрийн төлөвлөлт" БД 41-102-11 (ЗТБХБ-ын сайдын 2011 оны 344 дүгээр тушаал); - "Төв дамжуулах (Магистраль) хоолой" БНбД 44-01-08 (ЗТБХБ-ыг сайдын 2008 оны 35 дугаар тушаал); - Бусад холбогдох норм, дүрэм, заавар, стандарт
6	Баримт бичгийн бүрдэл	<u>Сүүрь судалгаа:</u> • Байр зүйн зураг М1:1000 • Инженер-геологийн судалгааны дүгнэлт • Ерөнхий төлөвлөлтийн хүрээнд эрэлт хэрэгцээ, эх үүсвэр, хангамж, хүчин чадлын судалгаа, өнөөгийн байдлын үнэлгээ. <u>Зураглалын материал:</u> • Инженерийн шугам сүлжээний нэгдсэн зураг М1:1000 • Дулаан хангамж /эх үүсвэр, шугам сүлжээний барилга, байгууламж/ М1:1000 • Ус хангамж, ариутгах татуурга /эх үүсвэр, шугам сүлжээний барилга байгууламж/ М1:1000 • Цахилгаан хангамж /эх үүсвэр, шугам сүлжээний барилга байгууламж/ М1:1000 <u>Ажлын зураг:</u> • Дулаан хангамжийн эх үүсвэр, шугам сүлжээний ажлын зураг • <u>Магадалын дүгнэлт /ерөнхий болон хавсралт/</u> • Инженерийн шугам сүлжээний иж бүрэн ажлын зураг төсөл. Тохижилт, бүтээн байгуулалт инженерийн бэлтгэл арга хэмжээ: • Инженерийн бэлтгэл арга хэмжээ төлөвлөх /Суурьшлын хэсгийг бүрэн хамруулахаар тооцно./ • Сумын төвийн шинээр боловсруулагдаж байгаа ерөнхий төлөвлөгөөний төслийг судлан төлөвлөх.

		• Батлагдсан (зураг төсөл, тайлбар бичиг)-г хэвлэмэл болон файл байдлаар (CD-нд бичиж) 4 хувь бэлтгэж, захиалагчид эх хувь 1, хуулбар 3 хувийг хүлээлгэж өгнө.
7	Шийдвэрлэх үндсэн асуудлууд	Инженерийн шугам сүлжээ: • Дулаан хангамжийн нэгдсэн эх үүсвэртэй ба шинээр холбогдох сумын төвийн гэр хорооллын айл өрхүүд, албан байгууллагууд, үйлчилгээний байгууллагууд холбогдохоор тусгах. • Сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төлөвлөлтөд тусгагдсан шинээр байгуулагдах амины орон сууц, төрийн үйлчилгээний барилга олон нийт үйлчилгээний барилга суурьшлын хэсэгт инженерийн нэгдсэн шугам сүлжээнд холбохоор төлөвлөлт хийх. • Зураг төслийг боловсруулахдаа "Хот байгуулалтын мэдээллийн сангийн таних тэмдгийн стандарт" -ыг баримтлан үндэсний орон зайн өгөгдлийн дэд бүтцийн ХБК-ын мэдээллийн сангийн суурь нөхцлийг бүрдүүлэх. • Одоо байгаа төвлөрсөн дулаан хангамжийн эх үүсвэр, дулааны 3 хос шугамыг бүрэн шинэчлэн нийгмийн хамгааллын барилгууд, аж ахуйн нэгж, айл өрхүүдийг холбохоор хийх. • Нэгдсэн дулааны эх үүсвэрийн барилгыг цэвэр усны эх үүсвэрийн байршлаас шалтгаалан шинээр төлөвлөх • Цэвэр усны эх үүсвэрийн худгийн болон нөөцийн усан сангийн барилга төлөвлөх • Ус цэвэршүүлэх төхөөрөмж 2 ширхэг • Цэвэр усны 50 тоннын нөөцийн сав 2 ширхэгийг төлөвлөх • Цэвэр усны бичил лаборатори төлөвлөх • Үерээс хамгаалах далан суваг , шуудуу, хашлага барих • Нэгдсэн бохир усны шугамын ажлыг гүйцэтгэж хоногт 50-150 м3/хоног хүчин чадал бүхий цэвэрлэх байгууламж төлөвлөх • Бохирын төв шугамыг шинээр төлөвлөх • Төвлөрсөн дулаан, цэвэрлэх байгууламж, цэвэр усны эх үүсвэрийн барилгуудын гадна цахилгаан хангамжийг техникийн нөхцлийн дагуу төлөвлөх • Инженерийн шугам сүлжээний дагуу өндөржилттэй зураг хийж мэдээллийн санд бүртгүүлэх • Дулаан хангамжийн эх үүсвэр, түүний үндсэн болон туслах тоноглол сүлжээний усны насос, ус боловсруулах систем, ялтсан дулаан солилцуур зэргийг оновчтой, нөөцтэй байхаар тооцооллыг хийж тусгах
8	Инженерийн байгууламж, шугам сүлжээний эх үүсвэр, хангамж	<u>Дулаан хангамж:</u> • УДДТ-3 халаалтад 15,Гкал/цаг шугамын диаметр 1-р хэлхээний шугам нь 2Ф125мм, 2-р хэлхээний 2Ф125мм-ийн шугамаар тус тус гардаг.
9	Эдийн засгийн тооцоо, төсөв	- Зураг төсөлд тусгагдсан шугам сүлжээний ажилбар тус бүрээр ажлын төсөв боловсруулах ба нэгдсэн төсвийн нэгтгэл хүснэгтээр нийт хөрөнгө оруулалтын ажлыг нэгтгэж төсөвлөнө. - Төсвийг ESTIMATOR PRO -21 программ болон эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн бусад программаар тооцно.
10	Төслийн онцгой нөхцөл	- Сумын төвийн аж ахуйн нэгж, үйлчилгээ, төсвийн байгууллага, нийтийн орон сууц, айл өрхүүд шинээр төлөвлөгдөж байгаа барилга байгуулажийн инженерийн шугам сүлжээнд холбох. - Инженерийн шугам сүлжээний трасс дагуу үерийн усны хамгаалах шуудуу, далангийн ажлыг төлөвлөх - Нийт хэрэглэгчийн ачаалал тооцсоны үндсэн дээр хүчин чадлыг зөв тохируулан төлөвлөх. - Шугам сүлжээ болон түүнтэй холбогдох барилга байгууламжийн

		угсралтын ажил гүйцэтгэхэд эдийн засгийн хувьд үр ашигтай орчин үеийн дэвшилтэт техник технологи
11	Зураг төсөл боловсруулах хугацаа	- Гэрээ байгуулснаас хойш 2 сар /Магадлалын дүгнэлт гарч батлуулах хугацаа орсон./
12	Шаардагдах хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр	- Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумын Засаг даргын Тамгын газар - Зураг төсөл боловсруулах үнэд геодези, инженер геологийн судалгаа, зураг төсөл боловсруулах, магадлалаар хянуулан батлуулах, зөвшөөрөлцөх зардал, НӨАТ зэрэг бүх зардлыг оруулан тооцно
13	Захиалагч байгууллага	- Барилга, хот байгуулалтын яам, Сэлэнгэ аймгийн ЗДТГазар.
14	Гүйцэтгэгч байгууллага	- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу сонгон шалгаруулна.
15	Зөвшөөрөлцөх байгууллага	- Баруунбүрэн сумын ЗДТГ, аймгийн ерөнхий архитектор, ГХБХБГазар, хангагч байгууллагуудтай зураг төсөл зөвшөөрөлцөх - Ажлын зураг төслийн баримт бичигт магадлалын нэгдсэн дүгнэлт гаргуулах;

ХЯНАН ЗӨВШӨӨРСӨН:

1. СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЕРӨНХИЙ АРХИТЕКТОР — Б.ХАНГАЛ

БОЛОВСРУУЛСАН:

1. БАРУУНБҮРЭН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ — Н.АЛТАНЦЭЦЭГ